

НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Багануур дүүргийн Тээвэр зохицуулалтын алба ААТҮГ-ын 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Аудитын код: **НТАГ-2024/34/НА-СТА-ОНА**

| | |
|--|--|
| <p>Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2024он</p> | <p>Эн Ай Ти Эс баланс Аудит ХХК-ийн захирал: Ш.Ичинхорлоо Утас: 99102291 Цахим хаяг: ichinhorloo@gmail.com</p> <p>Аудитын менежер: И.Туяа Утас: 99298711 Цахим хаяг: Tuyaishjamts@gmail.com</p> <p>Аудитор: С.Удвал Цахим хаяг: udval@gmail.com</p> <p>Аудитыг гүйцэтгэсэн: Эн Ай Ти Эс баланс Аудит ХХК Утас: 77820808 Цахим хаяг: NITS Audit</p> |
|--|--|

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛ ДЭХ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,
Утас: 7000 7734, Факс: (976-11) 32 01 54,
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

Аудит. ДЗ. 15 № 577

танай _____-ны № _____-т

БАГАНУУР ДҮҮРГИЙН ТЭЭВЭР
ЗОХИЦУУЛАЛТЫН АЛБА
ААТҮГ-ЫН ДАРГА
Б.ОЮУНБААТАР ТАНАА

АУДИТЫН ДҮГНЭЛТ

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Багануур дүүргийн Тээвэр зохицуулалтын алба ААТҮГ-ын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон эдийн засгийн зорилтот түвшинд аудит хийлээ.

Багануур дүүргийн Тээвэр зохицуулалтын алба ААТҮГ-ын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Санхүүгийн тайлангийн тухай болон аудитын тайлангийн тухай хэрэглэгчдийн анхаарал хандуулах, ач холбогдолтой зүйлийн талаар тодруулахад санхүүгийн тайланд толилуулаагүй асуудал гараагүй болно.

Аудитын гол асуудал

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

Бусад асуудлын хэсэг

Удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Тээвэр зохицуулалтын алба ААТҮГ нь тайлант онд үйл ажиллагааны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 3 зорилтын хүрээнд 23 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, зорилт, арга хэмжээний гүйцэтгэл 95.0 хувийн биелэлттэй байна.

D:\Desktop\2024\Word\Явсан биеийн\2024.03.15 BND Төсвийн зохицуулалтын алба.docx

002022179

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



М.ЭРДЭНЭЖАРГАЛ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

| Мөрийн дугаар | Үзүүлэт | 2022 оны 12 сарын 31 | 2023 оны 12 сарын 31 |
|---------------|---|-----------------------|-----------------------|
| 1 | ХӨРӨНГӨ | | |
| 1.1 | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ | | |
| 1.1.1 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө | 335,390.89 | 4,962,329.98 |
| 1.1.2 | Дансны авлага | 7,025,000.00 | 7,025,000.00 |
| 1.1.5 | Бараа материал | 2,433,950.00 | 2,588,050.00 |
| 1.1.7 | Эргэлтийн хөрөнгийн дүн | 9,794,340.89 | 14,575,379.98 |
| 1.2.1 | Үндсэн хөрөнгө | 178,632,183.02 | 649,888,057.91 |
| 1.2.2 | Биет бус хөрөнгө | 1,900,000.00 | 1,900,000.00 |
| 1.2.3 | Эргэлтийн бус хөрөнгийн дүн | 180,532,183.02 | 651,788,057.91 |
| 1.3 | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН | 190,326,523.91 | 666,363,437.89 |
| 2 | ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН | | |
| 2.1 | ӨР ТӨЛБӨР | | |
| 2.1.1. | Дансны өглөг | 29,795,546.00 | 24,140,610.00 |
| 2.1.2. | Татварын өр | 19,188,366.00 | 20,729,684.00 |
| 2.1.3. | Цалингийн өглөг | 5,351,205.00 | 509,870.00 |
| | Хойшлогдсон орлого | | 520,003,532.38 |
| 2.1.4. | НДШ-ийн өглөг | 54,389,268.00 | 44,800,000.00 |
| 2.1.5 | Богино хугацаат өр төлбөрийн дүн | 108,724,385.00 | 610,183,696.38 |
| 3.0 | ЭЗДИЙН ӨМЧ | | |
| 3.1 | Өмч | | |
| 3.1.1 | Төрийн | 670,642,000.00 | 670,642,000.00 |
| 3.1.3 | Эздийн өмчийн бусад хэсэг | 1,900,000.00 | 1,900,000.00 |
| 3.1.4 | Хуримтлагдсан ашиг | (590,939,861.09) | (616,362,258.49) |
| 3.1.4.1 | Тайлангийн үеийн ашиг | 0.0 | (25,422,397.40) |
| 3.1.4.2 | Өмнөх үеийн ашиг | (590,939,861.09) | (590,939,861.09) |
| 3.2 | Эздийн өмчийн дүн | 81,602,138.91 | 56,179,741.51 |
| 4.0 | ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН | 190,326,523.91 | 666,363,437.89 |

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

/төгрөгөөр/

| Мөрийн дугаар | Үзүүлэлт | 2022 оны 12- сарын 31 | 2023 оны 12- сарын 31 |
|---------------|---|-------------------------|------------------------|
| 1 | Борлуулалтын орлого (цэвэр) | 198,488,500.00 | 173,543,795.00 |
| 2 | Борлуулалтын өртөг | 257,220,211.37 | 85,948,779.51 |
| 3 | Нийт ашиг(алдагдал) | (58,731,711.37) | 87,595,015.49 |
| 4 | Түрээсийн орлого | 1,300,000.00 | |
| 5 | Бусад орлого | 43,150,801.56 | 26,846,516.00 |
| 6 | Үнэ төлбөргүй орлого | | 53,353,131.51 |
| 7 | Орлогын дүн | 44,450,801.56 | 80,199,647.51 |
| 8 | Борлуулалт, маркетингийн зардал | - | - |
| 9 | Ерөнхий ба удирдлагын зардал | 68,995,411.63 | 193,171,160.4 |
| 10 | Санхүүгийн зардал | 78,600.00 | 45,900.00 |
| 11 | Бусад зардал | 20,782,300.00 | 0.0 |
| 12 | Зардлын дүн | 89,856,311.63 | 193,217,060.40 |
| 13 | Татвар төлөхийн өмнөх ашиг(алдагдал) | (104,137,221.44) | (25,422,397.40) |
| 14 | Орлогын татварын зардал | | |
| 15 | Татварын дараах ашиг(алдагдал) | (104,137,221.44) | (25,422,397.40) |
| 16 | Бусад олз/гарз | | |
| 17 | Тайлант үеийн цэвэр ашиг(алдагдал) | (104,137,221.44) | (25,422,397.40) |

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

| Мөрийн дугаар | Үзүүлэлт | 2022 оны 12- сарын 31 | 2023 оны 12- сарын 31 |
|---------------|--|-----------------------|-----------------------|
| 1.1 | Мөнгөн орлогын дүн (+) | 242,939,301.56 | 200,390,311.0 |
| 1.1.3 | Бараа борлуулж үйлчилгээ үзүүлсэн орлого | | 192,109,656.00 |
| 1.1.6 | Бусад мөнгөн орлого | 44,450,801.56 | 8,280,655.00 |
| 1.2 | Мөнгөн зарлагын дүн (-) | 242,982,633.01 | 195,763,371.91 |
| 1.2.1 | Ажиллагчдад төлсөн | 105,154,916.39 | 64,535,590.38 |
| 1.2.2 | Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн | 2,000,000.00 | 27,909,243.50 |
| 1.2.3 | Бараа материал худалдан авахад төлсөн | 62,903,523.50 | 81,594,780.50 |
| 1.2.4 | Ашиглалтын зардалд төлсөн | 5,123,685.23 | 1,620,250.00 |
| 1.2.5 | Түлш шатахуун, тээврийн хөлс,сэлбэг хэрэгсэлд төлсөн | 27,293,586.00 | 5,375,000.00 |
| 1.2.6 | Даатгалын төлбөрт төлсөн мөнгө | | 72,205.90 |
| 1.2.7 | Татварын байгууллагад төлсөн | | 5,651,201.63 |
| 1.2.8 | Хүүгийн төлбөрт төлсөн мөнгө | 241,908.51 | |
| 1.2.9 | Бусад мөнгөн зарлага | 40,265,013.38 | 9,005,100.00 |

| | | | |
|-----|--|-------------|--------------|
| 1.3 | Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн | (43,331.45) | 4,626,939.09 |
| 4 | Бүх цэвэр мөнгөн гүйлгээ | (43,331.45) | 4,626,939.09 |
| 5 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 378,722.34 | 335,390.89 |
| 6 | Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 335,390.89 | 4,962,329.98 |

2.4. Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

| № | Үзүүлэлт | Өмч | Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл | Эздийн өмчийн бусад хэсэг | Хуримтлагдсан ашиг | Нийт дүн |
|----|---|----------------|-------------------------------------|---------------------------|--------------------|------------------|
| 01 | 2021 оны 12 сарын 31-ээрх үлдэгдэл | 382,342,000.00 | | | (327,461,772.87) | 54,880,227.13 |
| 02 | НББ-н бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга | | | | | |
| 03 | Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал) | | | | (263,478,088.22) | (263,478,088.22) |
| 04 | Өмчид гарсан өөрчлөлт | 288,300,000.00 | | | | 288,300,000.00 |
| 05 | Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн | | | 1,900,000.00 | | 1,900,000.00 |
| 06 | 2022 оны 12 сарын 31-ээрх үлдэгдэл | 670,642,000.00 | | 1,900,000.00 | (590,939,861.09) | 81,602,138.91 |
| 07 | НББ-н бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга | | | | | |
| 08 | Залруулсан үлдэгдэл | 670,642,000.00 | | 1,900,000.00 | (590,939,861.09) | 81,602,138.91 |
| 09 | Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал) | | | | (25,422,397.40) | (25,422,397.40) |
| 10 | Залруулсан үлдэгдэл | | | | | |
| 11 | Өмчид гарсан өөрчлөлт | | | | | |
| 13 | 2023 оны 12 сарын 31-ээрх үлдэгдэл | 670,642,000.00 | | 1,900,000.00 | (616,362,258.49) | 56,179,741.51 |

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

| № | Үзүүлэлтүүд | 2022 он | | 2023 он | | /төгрөгөөр/ Зөрүү | Хувь |
|-------|------------------------------|-----------------------|-----------------------|-----------------------|-----------------------|----------------------|--------------|
| | | Гүйцэтгэл | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Төлөвлөгөө | | |
| 1 | Нийт орлого | 242,939,301.56 | 174,600,000.00 | 253,743,442.51 | 253,743,442.51 | 79,143,442.51 | 145.3 |
| 1.1 | Нөхөн олговрын орлого | 198,488,500.00 | 168,600,000.00 | 169,194,000.00 | 169,194,000.00 | 594,000.00 | 100.3 |
| 1.2 | Бусад орлого | 1,300,000.00 | | 53,353,131.00 | 53,353,131.00 | 53,353,131.00 | 0.0 |
| 1.3 | Үнэмлэхийн орлого | 1,800,000.00 | | 1,120,700.00 | 1,120,700.00 | 1,120,700.00 | 0.0 |
| 1.4 | Үйл ажиллагааны бусад орлого | 41,350,800.00 | 5,000,000.00 | 3,229,100.00 | 3,229,100.00 | -1,770,900.00 | 64.5 |
| | Бусад | 3,100,000.00 | 1,000,000.00 | 26,846,511.51 | 26,846,511.51 | 25,846,511.51 | 2684.6 |
| 2 | Нийт зардал | 347,076,500.00 | 279,104,600.00 | 279,165,840.71 | 279,165,840.71 | 5,764,245.71 | 2.0 |
| 2.2.1 | Ажиллагсдад төлсөн | 138,032,400.00 | 90,000,000.00 | 79,234,510.00 | 79,234,510.00 | 10,756,490.00 | 88.0 |

| | | | | | | |
|--------|---------------------------------------|-----------------|---------------|-----------------|---------------|-------|
| 2.2.2 | Нийгмийн даатгалын зардал | 18,432,700.00 | 12,150,000.00 | 10,235,936.40 | -1,914,063.60 | 84.2 |
| 2.2.3 | Бичиг хэргийн зардал | 3,204,800.00 | 600,000.00 | 305,100.00 | -294,900.00 | 50.9 |
| 2.2.4 | Шуудан холбоо | 574,900.00 | 211,200.00 | 389,600.00 | 178,400.00 | 184.5 |
| 2.2.5 | Шатахуун, сэлбэгийн зардал | 65,858,200.00 | 75,840,000.00 | 85,948,780.31 | 10,108,780.31 | 112.0 |
| 2.2.6 | Хөдөлмөр хамгаалал | 2,435,500.00 | - | - | | 0.0 |
| 2.2.7 | Сургалт | 830,000.00 | | | | 0.0 |
| 2.2.8 | Ашиглалтын зардал | 2,621,400.00 | 1,440,000.00 | 275,350.00 | -1,164,650.00 | 19.1 |
| 2.2.9 | Граж түрээсийн зардал | 10,277,600.00 | 16,080,000.00 | - | 16,080,000.00 | - |
| 2.2.10 | Бусад зардал | 94,638,600.00 | 82,783,895.00 | 107,326,689.00 | 24,543,289.00 | 129.6 |
| 2.2.11 | Бусад татвар даатгал | 1,366,500.00 | | 1,152,880.00 | 1,152,880.00 | - |
| 2.2.12 | Зээлийн хүү | 8,803,900.00 | | | | |
| 2.2.13 | Бусад олз гарз | - | | 5,703,005.00 | | |
| 2.2.14 | Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал) | -104,137,200.00 | | (25,422,397.40) | | |
| 2.2.15 | Татварын зардал | | | 0.0 | | |
| 2.2.16 | Татварын дараах ашиг (алдагдал) | -104,137,200.00 | | (25,422,397.40) | | |

3. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Аудитаар нийт 225,625.0 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс аудитын явцад 79,045.9 мянган төгрөгийн 4 алдааг залруулсан, 509.8 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт бичигдсэн, 14,035.9 мянган төгрөгийн зөрчилд 3 албан шаардлага хүргүүлсэн, 132,033.4 мянган төгрөгийн зөрчилд 3 зөвлөмж өгсөн.

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|--|------------|-----------------|-----------------------------------|-----------------|--------------------------|----------------|------------|-----------------|--------------|-----|---------|-----|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Залруулсан | | Залруулаагүй | | Тоо | Дүн |
| | | | | | | | Тоо | Дүн | Тоо | Дүн | | |
| Үндсэн хөрөнгийг санхүүгийн тайланд дутуу бүртгэсэн | 1 | 53,353.2 | 1 | 53,353.2 | | | 1 | 53,353.2 | | | | |
| Цалингийн тооцоог нийгмийн даатгалын тайлангаас дутуу илэрхийлсэн | 1 | 898.9 | 1 | 898.9 | | | 1 | 898.9 | | | | |
| Орлогын дэлгэрэнгүй тайланд цалингийн зардлыг дутуу илэрхийлсэн. | 1 | 16,637.6 | 1 | 16,637.6 | | | 1 | 16,637.6 | | | | |
| Нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг орлогын дэлгэрэнгүй тайланд илүү илэрхийлсэн | 1 | 8,156.2 | | 79,045.9 | 1 | 8,156.2 | 1 | 8,156.2 | | | | |
| Дүн | 4 | 79,045.9 | 3 | 70,889.7 | 1 | 8,156.2 | 4 | 79,045.9 | | | | |

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | Үүнээс | | | | |
|--------------------|-------------|---------------|-----------------|---------|--------------------------------------|------------------------------|
| | | Төлбөрийн акт | Албан шаардлага | Зөвлөмж | Хариуцлага тооцуулах албан шаардлага | Хууль, хяналтын байгууллагад |
| | | | | | | |

| | | | | | | | | | | | шилжүүлсэн асуудал | |
|--|----------|-----------------|----------|--------------|----------|----------|----------|-----------------|----------|---------------------|--------------------|-----|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Цалингийн өглөг үүсгэсэн | 1 | 509.8 | 1 | 509.8 | | | | | | | | |
| Бараа материалын эдийн засгийн ангиллыг буруу ангилсан | 1 | 2,588.0 | | | | | 1 | 2,588.0 | | | | |
| Худалдан авалтыг цахим төлбөрийн баримтаар баталгаажуулаагүй, | 1 | 63,915.7 | | | | | 1 | 63,915.7 | | | | |
| Байгууллагын үйл ажиллагаанд мөрдөх НБББББ боловсруулан мөрдөж ажиллах өмнөх оны аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй | 1 | 0 | | | 1 | 0 | | | | | | |
| Хуримтлагдсан элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн боловч ашиглах боломжтой хөрөнгийг дахин үнэлүүлэх тухай өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй | 1 | 0 | | | | | | | 1 | 0 | | |
| Дүн | 5 | 67,013.5 | 1 | 509.8 | 1 | 0 | 2 | 66,503.7 | 1 | 0 | | |

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал /мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | |
|---|-------------|-----------------|---------------|-----|-----------------|-----|---------|----------|--------------------------------------|----------|-----------------|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Тоо | Тоо | Дүн | тоо | Дүн | |
| Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил | | | | | | | | | | | |
| Тайлант хугацаанд 14,035.9 мянган төгрөгийн 1 мэдээллийг байршуулаагүй байна, өмнөх оны аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлж ажиллаагүй | 1 | 14,035.9 | | | | | | | | 1 | 14,035.9 |
| Дүн | 1 | 14,035.9 | | | | | | | | 1 | 14,035.9 |
| Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийн талаар | | | | | | | | | | | |
| ХХОАТ, НДШ-ийн өр төлбөр үүсгэсэн | 1 | 65,529.7 | | | | | | 1 | 65,529.7 | | |
| Дүн | 1 | 65,529.7 | | | | | | 1 | 65,529.7 | | |
| Нийт дүн | 2 | 79,565.6 | | | | | | 1 | 65,529.7 | 1 | 14,035.9 |



НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АКТ

2024 оны 03 сарын 15 өдөр

Дугаар 51/21725351

Улаанбаатар хот

ИТГАГ- 0024/24/11А-СТД-611А

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Багануур Тээвэр зохицуулалтын алба ААТҮГ-ын 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант хугацаанд ажиллагсдад олговол зохих цалинг 509,800.00 (таван зуун есөн мянга найман зуу) төгрөгөөр дутуу тооцон олгож өглөгийн дансанд бүртгэж тайлагнаагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5."Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил гүйлгээг гарахаас өмнө хянан баталгаажуулах" гэж заасныг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгаагдагч этгээд төсөө, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно.", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3.3."цалин хөлс, шагнал урамшуулал, тэтгэмжийг зөрүүтэй тооцож олгосон; заалтад заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1.Багануур Тээвэр зохицуулалтын алба ААТҮГ-ын Ажилтанд дутуу олгосон 509,800.00 (таван зуун есөн мянга найман зуу) төгрөгийг холбогдох ажилтанд тооцож олгох;

2.Төлбөрийн актын биелэлтийг нотлох баримтын хамт 2024 оны 07 дугаар сарын 01-ний дотор Нийслэлийн төрийн аудитын газарт¹ ирүүлэхийг Багануур Тээвэр зохицуулалтын алба ААТҮГ-ын дарга Б.Оюунбаатар, нягтлан бодогч Б.Наранцэцэг нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН¹:

ЭН АЙ ТИ ЭС БАЛАНС АУДИТ ХХК-НИЙ
ЗАХИРАЛ

Ш.ИЧИНХОРЛОО

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН
ХЭЛТСИЙН ДАРГА,

АУДИТЫН МЕНЕЖЕР

Х.ТҮВШИНБАЯР

Я.АЛТАНЦЭЦЭГ



¹ Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 4 давхар

002051011



НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 03 сарын 15 өдөр

Дугаар 174/21725351

Улаанбаатар хот

ИТАС-2024/34/МА-СТА-01А

Сахилгын хариуцлага тооцуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Багануур дүүргийн Тээвэр зохицуулалтын албаны 2023 оны санхүүгийн тайлан, эдийн засгийн зорилтот түвшинд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн хуримтлагдсан элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн үндсэн хөрөнгийг дахин үнэлэх талаар холбогдох байгууллагад хандаж шийдвэрлүүлэх 296/19425085 дугаартай албан шаардлагыг хугацаанд нь бүрэн хэрэгжүүлээгүй байна.

Энэ нь Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам"-ын 19.1-т "Шалгагдагч этгээд аудитаар өгсөн зөрчил дутагдлыг арилгах, асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн зөвлөмжийн дагуу зохих ёсоор арга хэмжээ авч, залруулах ажлыг зохион байгуулсан байна", 19.2-т "Шалгагдагч этгээд аудитын тайланг баталгаажуулсан тушаалд заасан хугацаанд багтаан албан шаардлага, төлбөрийн акт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлтийг Төрийн аудитын байгууллагад тайлагнана" гэж заасныг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.3-т "Энэ хуулийн 42.1, 42.2-т заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд төрийн аудитын байгууллага тухайн албан хаагчид холбогдох сахилгын шийтгэл ногдуулах талаар эрх бүхий албан тушаалтанд албан шаардлага өгөх ба эрх бүхий албан тушаалтан ямар шийдвэр гаргасан талаараа албан шаардлагад заасан хугацаанд төрийн аудитын байгууллагад хариу мэдэгдэнэ" гэсэн заалтыг үндэслэн **ШААРДАХ нь:**

1.Өмнөх аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй байгууллагын дарга Д.Оюунбаатарт хуульд заасны дагуу сахилгын шийтгэл ногдуулж, биелэлтийг 2024 оны 4 дүгээр сарын 20-ны өдрийн дотор Нийслэл дэх Төрийн аудитын газарт ирүүлэхийг Багануур дүүргийн Засаг дарга С.Даваасүрэнд даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН1:

ЭН АЙ ТИ ЭС БАЛАНС АУДИТ
ХХК-ИЙН ЗАХИРАЛ

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН
ХЭЛТСИЙН ДАРГА

АУДИТЫН МЕНЕЖЕР

Ш.ИЧИНХОРЛОО

Х.ТҮВШИНБАЯР

Я.АЛТАНЦЭЦЭГ



¹ Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 4 давхар

002042843



НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 03 сарын 15 өдөр

Дугаар 176/21225351

Улаанбаатар хот

ИТАГ-2024/ЗМ/ЧМ-СТА-077Д

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Багануур дүүргийн Тээвэр зохицуулалтын албаны 2023 оны санхүүгийн тайлан, эдийн засгийн зорилтот түвшинд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулж, үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллах зөвлөмж өгснийг хэрэгжүүлэн ажиллаагүй байна. Энэ нь Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам"-ын 19.1-д "Шалгаагдагч этгээд аудитаар өгсөн зөрчил дутагдлыг арилгах, асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн зөвлөмжийн дагуу зохих ёсоор арга хэмжээ авч, залруулах ажлыг зохион байгуулсан байна", 19.2-т "Шалгаагдагч этгээд аудитын тайланг баталгаажуулсан тушаалд заасан хугацаанд багтаан албан шаардлага, төлбөрийн акт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлтийг Төрийн аудитын байгууллагад тайлагнана" гэж заасныг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгаагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.10. "аудитаар илэрсэн алдаа, зөрчил түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол" заалтад заасныг үндэслэн **ШААРДАХ** нь:

1.Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллаагүй зөрчлийг арилгаж биелэлтийг биелэлтийг 2024 оны 4 дүгээр сарын 20-ны өдрийн дотор Нийслэл дэх Төрийн аудитын газарт ирүүлэх;

2.Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Багануур Тээвэр зохицуулалтын алба ААТҮГ-ын дарга Б.Оюунбаатар, нягтлан бодогч Б.Наранцэцэг нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨНІ:

ЭН АЙ ТИ ЭС БАЛАНС АУДИТ
ХХК-ИЙН ЗАХИРАЛ

САНХҮҮНИЙЦЛИЙН АУДИТЫН
ХЭЛТСИЙН ДАРГА

АУДИТЫН МЕНЕЖЕР

Ш.ИЧИНХОРЛОО

Х.ТҮВШИНБАЯР

Я.АЛТАНЦЭЦЭГ



¹ Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 4 давхар

002042839